

**НАС БАРСАН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙН  
ЗЭЭЛИЙГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНД ХУРИМТЛАГДСАН ХУРИМТЛАЛААС  
НЬ ХАСАЖ ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1. Хууль зүйн шаардлага**

Улс орон бүр л өөрийн орны онцлогт нийцсэн нийгмийн даатгалын тэр дундаа тэтгэврийн даатгалын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлдэг. Дэлхийн ихэнх улс орнуудын парламенийн анхаарлын төвд байдаг асуудал бол тэтгэврийн даатгалын шинэчлэл байдаг. Энэ нь нас, тэтгэвэр бодох аргачлал, шимтгэл төлөх доод хэмжээ, хугацаанд анхаарахаас гадна тогтолцооны өөрчлөлт хийж байна. Дэлхий нийтийн чиг хандлага тухайн хүн хэр хэмжээний шимтгэл төлнө түүнтэй уялдаатай тэтгэвэр авах чиглэл рүү тогтолцоогоо өөрчилж байна. Монгол Улсад үйлчилж байгаа нийгмийн хамгааллын бодлогын хувьд олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч зорилтод бүлгийн иргэдийн амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй байна. Ялангуяа өндөр насны иргэдийн тэтгэврийн хэмжээ бага байгаа. Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих төвшин 448340 төгрөг. Гэтэл дундаж тэтгэврийн хэмжээүүнээс дөнгөж дээгүүр байгаа байдал нь шударга, энэрэнгүй зарчимд суурилдаг манай улсын тэтгэврийн тогтолцоонд нийцэхгүй байна. Ийм учраас ахмадуудын дийлэнх нь зээл авч амьдралаа залгуулж байгаа бөгөөд түүнийгээ төлж чадахгүй насан эцэслэхэд үр хүүхдүүд нь зээл төлөхөөр хоцорч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... иргэнийхээ өмнө Төр хариуцна.", Монгол Улсын төрөөс хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогыг тодорхойлж нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгон улс орныхоо онцлогт нийцсэн тэтгэврийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2015-2030 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.1.1-д "Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;", 3.2.1-д "тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх", Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.5-д "цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ" гэж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.1.5-д "нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ" гэж тус тус заасан заалтууд хэрэгжихгүй байна. Хэрэв төрийн бодлого, шийдвэрүүд хэрэгжсэн бол ахмадууд тэтгэврийн зээл авахгүй байх боломж бүрдэх ёстой юм.

## 1.2. Практик шаардлага

Сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ ханш эрс нэмэгдэж тэтгэвэр авагчдын худалдан авах чадварт, ялангуяа ахмад настануудын амьжиргаанд хүндээр байгаагаа ихэнх өндөр настангууд тэтгэврийн зээл авч амьжиргаагаа залгуулж байна. Монгол Улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан 2018, 2019, 2020, 2022, 2023 онд нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 685.6 мянган төгрөгт хүрч, 2016 онтой харьцуулахад 2.2 дахин нэмэгдсэн боловч үнийн өсөлтөө гүйцэхгүй байгаа юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан 2023 оны арваннэгдүгээр сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангаас нийт 493.0 мянган иргэн тэтгэвэр авч байгаагаас 59 орчим хувь буюу 288.4 мянган тэтгэвэр авагч бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна. Түүнчлэн бүрэн тэтгэврийн доод хэмжээ 650.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 540.0 мянган төгрөгт хүрсэн. Ийм хэмжээний тэтгэврийн орлогоор амьдарч байгаа ахмадууд улс орон, үр хүүхэд, хойч ирээдүйнхээ төлөө насаараа зүтгэн хөдөлмөрлөсөн ч тэтгэврээс өөр орлогогүй тул амьдралынхаа наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Энэ нь тэднийг тэтгэврийн зээл авч амьдралаа залгуулахад хүрч байгаа юм.

Зарим ахмад настан баяраа тэмдэглэн өнгөрүүлэх үүднээс тэтгэврийн зээл их хэмжээний дүнгээр авах хүсэлтэй. Гэвч тэтгэвэр авагч бүрд зээл авах дүнгийн боломжит хугацаа харилцан адилгүй байдаг байна. Зээлдэгчийн өрийн түүх бусад зүйлсийг харгалзаж дээд тал нь банкууд 12-24 сараар тэтгэврийн зээл олгож байгаа юм. Ингэхдээ зарим банк бага сараар зээл авсан ч дахин нэмж авах боломжгүй гэдэг шийдвэр гаргаж байгаа юм. Тухайлбал, Хаан банк 12 сар, Төрийн банк, Голомт, Худалдаа хөгжлийн банк 24 хүртэлх сараар олгож байгаа төдийгүй тэтгэврийн зээлтэй тохиолдолд зарим нь хугацаа сунгахгүй байх шаардлага тогтоожээ. Банк бүрийн тэтгэврийн зээлийн нөхцөл харилцан адилгүй ч хүүний хувьд жилийн 15-16,5 хувь байна. Банкнаас хамаарч зээлдэгч эргэн төлөгдөх нөхцөлөө сонгоно. Эргэн төлөлтөд, сар бүр үндсэн зээлээ тэнцүү төлөх, сар бүр үндсэн зээл, хүүгийн төлбөрийн нийлбэр тэнцүү төлөх нөхцлүүдийг санал болгох зэргээр олон хүндрэл гардаг. Мөн зээл авахад гар дээрээ шууд бэлэн авч байгаа дүнгээс зээлийн хүүг бөөнд нь хасаж тооцдог. Өнгөрсөн 2021 оны статистикаар нийт өрхийн 55 хувь буюу 520 мянга орчим өрх зээлтэй амьдарч байна гэсэн судалгааг Санхүүгийн Зохицуулах Хороо гаргасан. Харин энэхүү үзүүлэлт 2022 онд 2.1 нэгж хувиар нэмэгдсэн бол 2023 оны зээлийн индексээр ч мөн өссөн дүнтэй гарчээ. Арилжааны банкны өгсөн мэдээллээр тэтгэвэр авагчдын дийлэнх нь 2024, 2025 оныг дуустал зээл авсан ч хугацааг сунгах хүсэлтэй байгаа аж.

Үндэсний статистикийн хорооноос Дэлхийн банктай хамтран хоёр жил тутамд танилцуулдаг ядуурлын түвшингийн 2022 оны үзүүлэлтээр манай улсын нийт хүн амын 914 мянга нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна

Эдгээр ядуу иргэдийн тоонд өндөр насны тэтгэврээр амьдардаг ахмадуудын олонх нь хамаарах болсныг амьдралын бодит нөхцөл, авч буй тэтгэврийн хувь хэмжээ, тэдний авч буй тэтгэврийн зээлийн дүн нотлон харуулж байна.

Төрийн зүгээс нийгмийн даатгалын хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх, хүний амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг хангаж

чадахуйц хэмжээний тэтгэвэр олгох нь төрийн үүрэг юм. Тэтгэвэр авагч иргэн бол төрөөс зүгээр сууж байгаад халамж нэхэж, төсөвт хүндрэл учруулаагүй. Тэд ажиллаж хөдөлмөрлөж тодорхой хугацаанд ирээдүйд эдийн засгийн баталгаатай амьдрах үүднээс Нийгмийн даатгалын шимтгэлээ тухайн цаг үеийнхээ мөнгөний ханшаар төлсөн. Тэгэхээр өөрийн бий болгосон хуримтлалаа ирээдүйд авахдаа амьдралын наад захын хэрэгцээ шаардлагыг нь хангаж чадахгүй, тэднийг ядууралд түлхэж тэтгэврийн зээл авахад хүргэж байна.

Монгол Улсын иргэдийн дундаж наслалт эрэгтэй 67.6, эмэгтэй 76.8 байхад иргэдийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлсэн нь олон жил хөдөлмөрлөж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэд тэтгэврийн насанд хүрээд тэтгэвэр авч чадахгүй эсхүл цөөхөн жил тэтгэвэр авахдаа зээлээс зээлийн хооронд амьдарсаар насан эцэслэж байгаа нь энэхүү хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлагатайг илэрхийлж байна.

Өндөр насны тэтгэврийн зээл аваад төлж чадаагүй нас барсан иргэд бол ажил хөдөлмөр эрхлэж, олсон орлогоосоо зохих хэмжээгээрээ Нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн буюу ирээдүйдээ, тэтгэвэр тогтоолгоод сайхан амьдрах алхамаа хийсэн, үүргээ биелүүлсэн хүмүүс. Гэтэл тэдгээр нас барсан тэтгэврийн зээл авсан зээлдэгчийн өрийг үлдсэн ар гэрийнхэн нь төлөх үүрэг хүлээж байгаа нь буруу тогтолцоо юм. Тэтгэврийн зээл өндөр дүнтэй олгогдохгүй, тухайн иргэний авч байгаа тэтгэврийн хэмжээтэй уялддаг. Нас барсан тэтгэврийн зээл авагчийн төлсөн Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ тэдний авсан зээлийг төлөх хэмжээнд дүйцэхүйц байх нь шударга ёсонд нийцэх юм.

**Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 5 заалттай. Өндөр настны тэтгэвэр авагч тэтгэврийн зээлд хамрагдаад түүнийгээ төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Энэхүү хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч иргэд банкнаас тэтгэврийн зээл авсан боловч төлж барагдуулаагүй байхдаа нас барсан бол түүний тэтгэврийн зээлийг Нийгмийн даатгалын сангаас барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа тул нийгмийн даатгалын газар болон банкуудад нэмэлт ажилтан шаардагдахгүй, нэмэлт үйл ажиллагаа явуулахгүй, нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.

Нас барсан зээлдэгч нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдаг учир төрийн зүгээс үргүй зардалд тооцогдохгүй. Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн зээл авагч нас барсан иргэний гэр бүл дотны хүнээ алдахаас гадна, нэмээд эдийн засгийн хувьд эрсдэлтэй үлддэг байдал байхгүй болно. Олон өрх айлд эдийн засаг, сэтгэл санааны эерэг байдал бий болно.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн болно.

---oOo---